

ШУА-ИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН 2001 ОНД

О.Батсайхан*

Олон улс судлалын хүрээлэнгийн эрдмийн хамт олны хувьд 2001 он эрдэм шинжилгээний ажлын амжилт арвинтай жил боллоо.

ШУА-ийн ерөнхийлөгчийн 2001 оны 6-р сарын 12-ны өдрийн 137 тоот тушаалаар тус хүрээлэнгийн дэргэд анх удаа Олон улс орон судлалын салбараар доктор(Ph.D)-ын зэрэг хамгаалуулах бие даасан зөвлөл 15 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулагдсан нь орон судлал, олон улсын харилцааны эрдэмтэн судлаачдыг бэлтгэн гаргахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. Тус хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл ОХУ-ын нэртэй монголч эрдэмтэн, түүхч С.Рошины шинжлэх ухааны докторын, горилогч С.Отгонбаатар* Б.Сэржавын доктор(Ph.D)-ын хамгаалалтуудыг хийлээ. Мөн зөвлөлөөр тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор С.Дамдинсүрэн, Н.Дангаасүрэн нарт *“Судалгааны профессор”* цол олголоо.

Манай ажилтнууд хариуцсан сэдэвт эрдэм шинжилгээний ажлын зэрэгцээ Улаанбаатарын их сургуулийн Ази судлалын салбарын болон МУИС, УБИС, Их засаг, Отгонтэнгэр зэрэг их дээд сургуулийн сургалтын ажилд идэвхтэй оролцож, Л.Жамсран, Л.Хайсандай, Д.Шүрхүү, Ц.Баатар, Л.Бэгзжав, Б.Сэржав нар түүх, хятад, япон хэл, орон судлал, олон улсын харилцааны талаар хичээл зааж оюутны диплом, магистр, докторантын 20 гаруй ажлыг удирдлаа.

2001 онд Монгол улсад шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 80 жил, ШУА байгуулагдсаны 40 жилийн ой тохиосонтой холбогдуулан “Монголын олон улс судлал” сэдвээр эрдэм шинжилгээний хурал хийж, байгууллагын түүхчилсэн үзэсгэлэн гаргаж, хүрээлэнгийн хүндэт дэвтэрт Ч.Далай, Ш.Бира, Н.Ишжамц,

* О.Батсайхан – ОУСХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph)

Л.Жамсран, Н.Дангаасүрэн нарын зэрэг нэртай эрдэмтдийг алдаршуулан бичив. Түүнчлэн тус хүрээлэнтэй ажил хэргийн талаар бүтээлчээр хамтран ажиллаж байдаг Японы улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Ханада, БНХАУ-аас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хуан Жякуй, АНУ-аас Монголд суугаа ЭСЯ -ны мэдээллийн албаны дарга М.Тереза, ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн орлогч захирал, профессор Ю.Ванин нарт **“Хүрээлэнгийн хүндэт доктор”** цол олгов.

Мөн Олон улсын нүүдлийн соёл иргэншил судлалын хүрээлэнгээс эрхлэн англиар гаргадаг, дэлхийн олон оронд түгэн тардаг нэр хүнд бүхий “Nomadic” сонины 2001 оны №19-д, “Өнөөдөр” сонины 2001 оны 6-р сарын 21-ны дугаарт, мөн “Хамаг Монгол” компани БСШУЯ-тай хамтран бэлтгэсэн “Монгол улсын Соёл, боловсрол, шинжлэх ухааны байгууллагууд” лавлахад тус тус хүрээлэнгээ болон хамт олныхоо амжилт ололтыг нэлээд дэлгэрэнгүй сурталчлав. Хүрээлэнгээс саяхан эрхлэн гаргасан “Mongolian Journal of International Affairs” №7, “Олон улс судлал” /2001 оны №1, 2/ сэтгүүлүүдийн чанар чансаа, өнгө үзэмжийг сайжруулахад ихээхэн анхаарал тавьсан бөгөөд цаашид олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлийн түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Түүхт ойнуудыг тохиолдуулан ахмад, нэр хүндтэй эрдэмтдийн хөдөлмөр бүтээлийг төр засгаас өндөр үнэлэн төрийн дээд шагнал, одон медалиар шагнав. Доктор, профессор Л.Жамсран “Шинжлэх ухааны гавьяат ажилтан” цол хүртэж академич Б.Лхамсүрэн “Сүхбаатарын одон”-гоор, доктор Л.Хайсандай, доктор С.Дашцэвэл нар “Алтан гадас” одонгоор шагнууллаа. Мөн тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор (Ph.D) Л.Бэгзжав, Н.Ариунгаа, О.Батсайхан, М.Хурметхан нар “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” цол тэмдгээр эрдэм шинжилгээний ажилтан Б.Батцэцэг БСШУЯ ны жуух бичгээр, нягтлан бодох Д.Дулмаа Сангийн яамны жуух бичгээр тус тус шагнагдсан нь бидний ажилд урам хайрласан хэрэг боллоо. Доктор (Ph.D) Л.Бэгзжав, Ц.Баатар нар Улаанбаатар их сургуулийн дэд профессор цол хүртэв. Мөн хүрээлэнгийн захиргаа жилийн ажлын үр дүн, гаргасан бүтээл зэрэг байдлыг

харгалзан үзэж эрхэлсэн ажилдаа тодорхой амжилт гаргасан С.Галя, Ш.Догмийчойдон, Ц.Баатар, З.Эрдэнэчимэг, Н.Цэцгээ, Н.Төмөр, Б.Сэржав нарыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. ШУА байгуулагдсаны 40 жилийн ойд зориулсан залуу эрдэмтдийн чуулганд “Олон улсын харилцааны онол шинжлэх ухааны судлагдхуун болох нь” сэдвээр эрдэм шинжилгээний ажилтан доктор (Ph.D) К.Дэмбэрэл илтгэл тавьж тэргүүн байр эзэллээ.

х х х

Олон улс судлалын хүрээлэнгийн эрдмийн хамт олон 2001 онд эрдэм шинжилгээний хоёр төслийг үргэлжлүүлэн дуусгаж, 2001-2004 онуудад хийж гүйцэтгэх онолын суурь судалгааны гурван сэдвийг ШУА-ийн Бага чуулганаар батлуулан хэрэгжүүлж ажлаа эхлээд байна. Үүнд

1999-2001 онд хэрэгжиж дууссан төсөл-

“Зүүн хойт Азийн бүс нутаг ба Монгол Улс”

“Монгол улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш”

2001- 2004 онд хэрэгжүүлж буй сэдэвт ажил

“Хөрш гүрнүүдийн бүс нутгаа хөгжүүлэх чиг бодлого ба Монгол улсын ашиг сонирхлыг уялдуулах асуудал”,

1. *“АНУ ба Өрнөдийн орнуудаас Монголд явуулж буй бодлого өнөөгийн байдал, хэтийн төлөв”,*

2. *“Азийн бүс нутгийн интеграцлалд Монгол улсын оролцох байр суурь, арга замын асуудал”*

х х х

2001 оны 1-р сард АНУ-ын ЭСЯ-тай хамтран тус хүрээлэн *“ХХ зуун дахь АНУ-ын ерөнхийлөгчийн засаглал”* сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг амжилттай зохион байгуулав. Сүүлийн 10 гаруй жил манай оронтой тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа нь эрчимтэй хөгжиж буй манай гуравдахь том түнш АНУ-ын улс төрийн тогтолцоо түүний дотор ерөнхийлөгчийн засаглалыг ойлгон сайтар таньж мэдэх, хоёр орны харилцааны түүх, өнөө, ирээдүйн талаарх дотоод гадаадын эрдэмтдийн үзэл бодолтой танилцаж, санал солилцсон нь эрдэм шинжилгээний

төдийгүй практикийн ихээхэн чухал холбогдолтой арга хэмжээ болов. Уг хурлын материалыг монгол, англи хэлээр ном болгон хэвлэж хот, хөдөөгийн нийт номын сан, сургуулиудад үнэгүй тараан хүргэж өглөө.

х х х

Манай хүрээлэнгийн судлаачдын хийж буй бас нэг шинэлэг ажил бол албан хэрэгцээнд зориулан “Судалгаа мэдээ” хэмээх судалгаа, мэдээллийн товхимлыг тогтмол бэлтгэн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад оролцож буй удирдах албан тушаалтнууд, холбогдох байгууллагуудад тарааж эхэлсэн явдал юм. Энэхүү “Судалгаа мэдээ”-ний эхний 2 дугаарыг “БНХАУ-ын дотоод гадаад бодлого” сэдвээр Хятад судлалын салбарын ажилтнууд хийсэн юм.

Манай хүрээлэн ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнтэй хамтран “Россия и Монголия: новый взгляд на взаимоотношения в XX веке” /Москва, 2001. 23 хх/ номыг саяхан хэвлүүлсэн нь сүүлийн 20 гаруй жилд анх удаа Монгол-Оросын эрдэмтэд хамтран туурвисан дорвитой бүтээл болсон юм. Энэхүү хамтын бүтээлд ХХ зууны Монгол-Оросын харилцааны эдрээтэй урьд өмнө бага судлагдсан олон асуудлыг архивын шинэ материалуудад түшиглэн шинэлэг байр сууринаас бичсэн тул гадаад дотоодын эрдэмтэн төдийгүй өргөн олон түмний сонирхлыг зүй ёсоор татна хэмээн үзэж байна. Доктор С.Дамдинсүрэнгийн 70 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал хийж түүний сүүлийн жилүүдэд бичиж нийтлүүлсэн бүтээлээс “Монголын тусгаар тогтнол: Эрин зууны баталгаажилт” нэгэн сэдэвт түүвэр эмхтгэлийг хэвлэн гаргав.

х х х

Манай хүрээлэн мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ы Зүүн хойт Ази судлалын хүрээлэнтэй тогтмол харилцаатай ажилладаг бөгөөд 2001 оны 3-р сарын 6-9-ны хооронд тус ОУСХ-ийн захирал Л.Хайсандай тэргүүтэй төлөөлөгчид ӨМӨЗО-нд ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр ӨМӨЗО-ы Зүүн хойт Ази судлалын

хүрээлэнгийн захирал, профессор Цао Жункайтай ажил хэргийн уулзалт хийж цаашид хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх талаар тохиролцон хамтын ажиллагааны гэрээгээ шинэчлэн байгуулав.

БНХАУ-ын Гирин мужийн Нийгмийн шинжлэх ухааны Академи болон Гирин мужийн Зүүн-Хойт Ази судлалын төвийн урилгаар тус хүрээлэнгийн захирал Л.Хайсандай нарын төлөөлөгчид 2001 оны 5-р сард Хятад улсад эрдэм шинжилгээний томилолтоор ажиллав.

Монгол улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Хятад улсын Гирин мужийн нийгмийн шинжлэх ухааны Академийн хооронд “Эрдэм шинжилгээний солилцоо хамтын ажиллагааны Гэрээ” байгуулж гарын үсэг зурав.

Мөн доктор М.Хурметхан Ираны ГХЯ-ны дэргэдэх Улс төр, олон улс судлалын хүрээлэнгийн урилгаар 2001 оны 4-р сарын 12-ноос нэг сарын хугацаатай Иран улсад эрдэм шинжилгээний томилолтоор ажиллаад ирэв.

Манай хүрээлэнгийн гадаад харилцаанд манай улсад суугаа элчин сайдын яамд нэлээд чухал байр суурь эзэлдэг. Тухайлбал, БНХАУ, АНУ, Япон, Солонгос зэрэг орны ЭСЯ манай судалгааны ажилд чухал хэрэгцээтэй ном, сэтгүүл өгөх, холбогдох ижил төстэй байгууллагатай харилцаа холбоо тогтоох, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, судлаач нарыг өөрийн оронд явуулж сурган, дадлагажуулахад ихээхэн тус дэмжлэг үзүүлж байна.

Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд Б.Сэржав Японы эрдэмтэнтэй хамтран “Япон-Монгол толь бичиг” (35 мянган үгтэй) хийж дуусган 2001 онд хэвлүүлсэн нь өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангахуйц эрдэм шинжилгээ практикийн ач холбогдолтой бүтээл болсон билээ. Энэхүү бүтээл нь хүрээлэнгээс шалгарч Академийн хэмжээний шилдэг бүтээлд нэр дэвшин удаалав.

2001 онд хүрээлэнгийн ажилтнууд нийтдээ ном товхимол 10, сэтгүүл 3, эрдэм шинжилгээний өгүүлэл 20 гаруйг бичиж нийтлүүлснээс гадна гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 18 илтгэл тавьж, практикийн болон удирдах дээд байгууллагад “Судалгаа мэдээ” хоёрыг шилжүүлэн өгсөн байна.

**Олон улс судлалын хүрээлэнгээс
2001 онд хэвлүүлсэн бүтээл**

1. “Монгол, Хятадын харилцаа нийгэм-эдийн засгийн зарим асуудал” /УБ, 2001. 12хх/
2. АНУ-ын ЭСЯ-тай хамтран “ХХ зуун дахь АНУ-ын ерөнхийлөгчийн засаглал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал УБ. 2001 он (англи, монгол хэлээр)
3. “БНХАУын дотоод гадаад бодлого” сэдэвт судалгаа мэдээ УБ.2001 он, №1 (2.5 х.х)
4. “Судалгаа мэдээ”. УБ, 2001, №2, (1 х.х)
5. ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнтэй хамтран “Россия и Монголия: новый взгляд на взаимоотношения в ХХ веке” /Москва, 2001. 23 хх/
6. Б.Сэржав. “Япон Монгол толь бичиг” (35 мянган үгтэй) Японы эрдэмтэнтэй хамтран УБ. 2001 он
7. С.Дамдинсүрэн “Монголын тусгаар тогтнол: Эрин зууны баталгаажилт” УБ.2001 он 15 х.х
8. Ц.Баатар. “The Chinggis heritage in the USA: Mongolian Americans in the 20 th century”. УБ. 2001
9. Н.Дангаасүрэн. “Улс тогтнох хүчин зүйлс”. УБ. 2001 он
10. “Хэвлэгдсэн бүтээлийн хэлхээс” (Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэдийн сүүлийн 10 жилд нийтлүүлсэн бүтээлийн нэрс) УБ. 2001 он

Хүрээлэнгийн сэтгүүл

1. “Mongolian Journal of International Affairs” №7, 2001
2. “Олон улс судлал” 2001 оны №1
3. “Олон улс судлал” 2001 оны № 2